

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар: 20

Улаанбаатар хот

**Төлөвлөгөөний биелэлт
дүгнэх тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 13 дугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 4.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК нь 2023 оны давхар даатгалын төлөвлөгөөний биелэлтийг урьдчилсан гүйцэтгэлээр хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэсүгэй.

2. 2023 оны давхар даатгалын төлөвлөгөөний урьдчилсан гүйцэтгэл, холбогдох тайланг “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-д заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ